

Ховд аймгийн Дөргөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

“Төлөөлөгчдийг чадавхижуулах”
дэд хөтөлбөр

“Төлөөлөгчдийг чадавхижуулах” дэд хөтөлбөр

Нэг. Үндэслэл

Төлөөлөгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах, чадавхижуулах.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нь нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан зохион байгуулж шийдвэрлэх үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтлан, иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд шийдвэрлэх бодит чадамжийг дээшлүүлэхэд оршино.

Гурав. Зорилт

- Шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;
- Төлөөлөгчдийг мэдээллээр хангах;
- Төлөөлөгчдийг сургалтанд хамруулах;
- Төлөөлөгчдийг туршлага судлуулах;
- Төлөөлөгчид хяналт шалгалтын үүргээ хэрэгжүүлэх;
- Төлөөлөгчид тойрогтоо ажиллах.

Дөрөв. Үйл ажиллагаа

4.1. Шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх

- Холбогдох албан тушаалтан болон мэргэжлийн байгууллагуудаас асуулга тавьж хариулт авах

- Иргэдээр хэлэлцүүлэг хийлгэх

4.2. Төлөөлөгчдийг мэдээллээр хангах. /Ажлын алба холбогдох байгууллагуудтай хамтран/

- ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хурлын талаар мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр

- Боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуй, халамж, татвар зэрэг салбар болон байгууллагуудын үйл ажиллагааны талаар танилцуулга мэдээлэл улирал тутам авах

- Уулзалт, ярилцлага хийх, сум, байгууллагуудаар явж ажилтай танилцах
- Ном, сонин хэвлэл, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахад дэмжлэг үзүүлэх

4.3. Төлөөлөгчдийг сургалтанд хамруулах.

- Аймаг бүсийн сургалт
- МНУХ, Удирдлагын академийн сургалт
- Орон нутагт зохион байгуулах сургалт

4.4.Төлөөлөгчдийг туршлага судлуулах.

- Сайн ажиллагаатай ИТХ-ын байгууллагуудын туршлага судлах, дотооддоо танилцах аялал зохион байгуулж эдийн засаг, нийгмийн хөгжил, чиг хандлага, шинэ санааг судлан нэвтрүүлэх

- Гадаад орнуудын өөрөө удирдах байгууллагуудын туршлага судлах, танилцах аялал зохион байгуулж эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, шинэ санааг судлан нэвтрүүлэх, хамтын харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх

4.5. Төлөөлөгчид хяналт шалгалтын үүргээ хэрэгжүүлэх.

/ЗДТГазар болон хяналтын байгууллагуудтай хамтран/

- Сумын Засаг дарга түүний тамгын газар
- Засаг даргын дэргэдэх газрууд
- Боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, байгаль орчин, ХАА гэх мэт салбарууд
- Татвар, хөдөлмөр, халамж, нийгмийн даатгал /босоо тогтолцоотой салбарууд/

4.6. Төлөөлөгчид тойрогтоо ажиллах /Сум, багийн Засаг дарга, удирдлагуудтай хамтран тогтмол ажиллах/

- Сонгогчидтой ажиллах
- Сумын тулгамдаж буй асуудал болон хөгжлийн асуудал

4.7. Багуудад “Төлөөлөгчдийн өдөр”-ийг зохион байгуулах.

/ИТХ-ын төлөөлөгчид, Ажлын алба, бусад албан байгууллагын ажилтнууд/

- Уулзалт зохион байгуулах
- Хэлэлцүүлэг
- Урлаг, спортын арга хэмжээ
- Судалгаа

4.8.Төлөөлөгч ба иргэдийн оролцоо.

/Ажлын алба, Багийн ИНХын дарга, багийн Засаг дарга нар хамтран/

- Багийн Иргэдийн Нийтийн хурлуудад оролцох
- Иргэдийн хэлэлцүүлгүүдэд оролцох

- Шийдвэр гаргахад иргэдээс санал авах

4.9.Төлөөлөгчдийг урамшуулах. /Тэргүүлэгчид, Ажлын алба/

- Төрийн одон медаль, салбарын шагнал
- Ном, сонин хэвлэлд бичиж алдаршуулах
- Урамшуулах

Тав. Хэрэгжүүлэх хугацаа

Төлөөлөгчдийн бүрэн эрхийн хугацаанд /2014- 2016 он/

Зургаа. Санхүүжилт

Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн зардал

Долоо. Хэрэгжүүлэгч байгууллага

ИТХ-ын Ажлын алба болон холбогдох байгууллагууд

Найм. Хөтөлбөрийн үр дүн

8.1. Нутгийн удирдлагын байгууллагын зүгээс харъяа нутаг дэвсгэрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үр нөлөөтэй хяналт хийх боломж бүрдэнэ.

8.2. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ нийгэм, эдийн засаг, өмчийн харилцааны бүхий л асуудлаа бие даан шийдвэрлэх үндсэн үүргээ хэрэгжүүлж, төлөөлөгчдийн шийдвэр гаргах, асуудал санаачлах, иргэдээ сонсох, тайлагнах чадамж дээшилнэ.

8.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрт иргэдийн оролцоо, санал санаачлага тусгалаа олж, төрийн ба төрийн бус байгууллагын ажлын уялдаа сайжрах нөхцөл бүрдэнэ.

8.4. Бүх шатны ИТХ-ын Төлөөлөгчдийн хариуцлага, санаачлага сайжирна.

**“Төлөөлөгчийг чадавхижуулах” дэд
хөтөлбөрийн төлөвлөгөө**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	Шаардагдах хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	
				Улсын төсөв	Орон нутгийн төсөв
1	Шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх	Тухай бүр	ИТХ		
2	Төлөөлөгчдийг мэдээллээр хангах.	Тухай бүр	Байгууллагууд		
3	Төлөөлөгчдийг МНУХ, Удирдлагын академийн сургалтанд хамруулах, дотоодын тэргүүн туршлага судлуулах	2015 он	ИТХ		6000,0
4	Төлөөлөгчдийг аймаг, бүсийн сургалтанд хамруулах.	Тухай бүр	ИТХ		
5	Орон нутагт сургалт зохион байгуулах	Жил бүр	ИТХ, ЗДТГ	200,0	
6	Төлөөлөгчдийг гадаадад туршлага судлуулах	2014 он	ИТХ		10000,0
7	Төлөөлөгчид хяналт шалгалтын үүргээ хэрэгжүүлэх	Жил бүр	ИТХ		
8	Төлөөлөгчийн тойрогтоо ажиллах	Тухай бүр	ИТХ	840,0	
9	Багуудад “Төлөөлөгчдийн өдөр”-ийг зохион байгуулах.	Жил бүр	ИТХ, ЗДТГ	200,0	
10	Төлөөлөгч ба иргэдийн оролцоо.	Тухай бүр			
11	Төлөөлөгчдийг урамшуулах.	Жил бүр		2200,0	
12	Иргэний танхимын орон нутгийн телевизийг камержуулах				5000,0

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:
Нарийн бичгийн дарга:
Гишүүдэд:

ИТХ-ын дарга
ИТХ-ын нарийн бичгийн дарга
Тэргүүлэгчид
Засаг дарга
ЗДТГ-ын дарга